

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.04.08-ны өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрээс:

4.1. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын шалгуур үзүүлэлтийн төслийг хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

4.2. “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журам”-ын төслийг хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

4.3. “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги 2030 он” баримт бичгийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны хөтөлбөрийн төслийн тухай хэлэлцээд Яамдаас санал авахаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4. Үндэсний аврах бригадын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт явуулсан дүнг 88,6 В үнэлгээтэй батлав.

4.5. Говь-Алтай аймаг дахь Улсын нөөцийн салбар, цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ажлын хариуцлага алдсан тус аймгийн ОБГ-ын дарга болон УНС-ын дарга нарт сахилгын арга хэмжээ тооцохоор шийдвэрлэв.

4.6. Баянхонгор аймаг дахь Улсын нөөцийн салбар, цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ажлын хариуцлага алдсан тус аймгийн ОБГ-ын дарга болон УНС, цэгийн няравуудад сахилгын арга хэмжээ тооцохоор шийдвэрлэв.

4.7. Өвөрхангай аймаг дахь Улсын нөөцийн салбар, цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ажлын хариуцлага алдсан тус аймгийн ОБГ-ын дарга болон УНС-ын дарга, нярав нарт сахилгын арга хэмжээ тооцохоор шийдвэрлэв.

4.8. Хэнтий аймаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбар, цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд тус аймгийн ОБГ-ын дарга, УНС-ын дарга, Хурх тосгон дахь цэгийн агрономич нарт сахилгын арга хэмжээ тооцохоор шийдвэрлэв.

4.9. Сүхбаатар аймаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбар, цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд УНС, цэгийн хашааг 2019.06.011-ний дотор барьж дуусган ашиглалтад оруулах үүрэг өгөв.

4.10. Төв аймаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбар, цэгүүдийн үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ажил сайжруулах хугацаат үүрэг өгөхөөр шийдвэрлэв.

4.11. Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн “Объект-03” салбарын үйл ажиллагаанд шалгалт явуулсан дүнг хэлэлцээд дахин шалгалт явуулахаар шийдвэрлэв.

4.12. Нийслэлийн Онцгой байдлын газрын Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагаанд албаны шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ажлын хариуцлага алдсан тус хэлтсийн дарга, нягтлан бодогч нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхөөр шийдвэрлэв.

4.13. Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд I улирлын байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд 94,0 А үнэлгээтэйгээр батлав. Ажлын үр дүнгээр зарим газар, хэлтсийн дарга нарыг сарын үндсэн цалингийн тодорхой хувиар урамшуулахаар шийдвэрлэв.

4.14. Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлын тухай сонсоод бэлтгэл ажлыг хангаж ажиллах талаар хугацаатай үүрэг өгөв.